



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 5 дугаар
сарын 01-ны өдөр

Дугаар 4-65

Улаанбаатар хот

Бүтэц зохион байгуулалтыг
өөрчлөх тухай

Нэг. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2000 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 47 тоот тогтоолыг үндэслэн "Авто зам барилгын Улаанбаатар" компани, "Дохио" нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг 2000 оны 05 дугаар сарын 01-нээр тасалбар болгон татан буулгаж, "Улаанбаатар зам засвар" компанид нэгтгэн зохион байгуулсугай.

Хоёр. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан Б.Мандатыг "Авто зам барилгын Улаанбаатар" компаний захирлын, Д.Лхагв-Очирыг "Дохио" үйлдвэрийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

Гурав. Татан буугдсан байгууллагуудын ажил, эд хөрөнгө хүлээлцэх комиссыг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байгаатай холбогдуулан "Улаанбаатар Зам засвар" компани /Б.Отгонсүрэн/-д ДААЛГАХ НЬ:

1. 1999 оны жилийн эцсийн тооллогоор дээрх үйлдвэрийн газруудад байсан үндсэн хөрөнгө, машин тоног төхөөрөмж, эд хогшил, түүхий эд материалыг дахин тоолж хүлээлцэн, дүнг нийслэлийн Өмчийн газарт ирүүлсүгэй.

2. 2000 оны 05 дугаар сарын 01-ний байдлаар ер, авлагатай байгууллага, хүмүүсийн жагсаалт гарган, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, дуусгалтын балансыг 2000 оны 05 дугаар сарын 15-ны дотор гаргаж ирүүлсүгэй.

3. "Улаанбаатар Зам засвар" компанийн шинэчилсэн дүрэм, бүтэц зохион байгуулалтын төслийг 2000 оны 05 дугаар сарын 20-ны дотор боловсруулж батлуулан ажиллахыг "Улаанбаатар Зам засвар" компани /Б.Отгонсүрэн/-д үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2000 оны
4-65 дугаар захирамжийн
хавсралт

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТӨӨР
ТАТАН БУУГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛ,
ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦЭХ КОМИСС

Комиссын дарга	Г.Өлзий	-Хот тохижилтын хэлтсийн дарга
Гишүүд:	С.Солонго	-Хотын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Наранцогт	-Нийслэлийн Өмчийн газрын мэргэжилтэн
	У.Эрдэнэ-Очир	-Нийслэлийн Өмчийн газрын мэргэжилтэн
	Т.Оюунсувд	-Нийслэлийн Өмчийн газрын мэргэжилтэн
	Б.Эрдэнэбат	-Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн
	Ү.Жаргал	-Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Отгонсүрэн	-“Улаанбаатар-Зам засвар” компанийн захирал
	Б.Мандат	-
	Д.Лхагва-Очир	-